



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Ховд сумын ерөнхий боловсролын сургуулийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ХОА-2026/081/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:
www.audit.mn

Ховд хот
2026 он

Дарга, тэргүүлэх аудитор: Х.Болдбаатар

Утас: 70433061 Цахим хаяг: boldbaatarkhu@audit.gov.mn

Аудитын менежер: А.Цэцэгсүрэн

Утас: 70432545 Цахим хаяг: tsetsegsurena@audit.gov.mn

Аудитор: Н.Батжаргал

Утас: 70432545 Цахим хаяг: batjargaln@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	2
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	5
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	6
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	6
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	7
3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	9
3.1. Төлбөрийн акт	9
3.2. Албан шаардлага	10
3.3. Хууль, хяналтын байгууллагад шилжүүлэх	11
3.4 ЗӨВЛӨМЖ	11
4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ	15
5. ТӨСВИЙН ЗАХИРАГЧИЙН АНГИЛЛААР АУДИТАД ХАМРАГДСАН БАЙДАЛ БА САНАЛ ДҮГНЭЛТИЙН ТАЛААРХ МЭДЭЭЛЛИЙН НЭГТГЭЛ	15

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



ХОВД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

84000 Цамбагарав баг, Жаргалант сум, Ховд аймаг
Утас/Факс: (976)-7043-3061
Email: khovd@audit.gov.mn

Болов. од. д.с. № 137

танай _____ -ны № _____ -т

ХОВД СУМЫН ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН
СУРГУУЛИЙН ЗАХИРЛЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ Х.ӨНЕР ТАНАА

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Ховд сумын ерөнхий боловсролын сургуулийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр “Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл” хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторовын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн доорх зөрчлүүд нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан бөгөөд дангаар буюу нийт дүнгээрээ санхүүгийн тайланд материаллаг нөлөөтэй боловч өргөн тархаагүй Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1, 41 дүгээр зүйлийн 41.2.1, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7, 14 дүгээр зүйлийн 14.4, 18 дугаар зүйлийн 18.1, 20 дугаар зүйлийн 20.1.4, 20.2.3, Ерөнхий боловсролын сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 5 дугаар зүйлийн 5.1.2, Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1, 61 дүгээр зүйлийн 61.1 дэх заалтуудтай нийцээгүй, санхүүгийн тайлагналын иж бүрэн байх, үнэн зөв байх, нийцсэн бөгөөд зохистой байх, эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна. Үүнд:

- Дотуур байрны журналын ирцийн бүртгэлээс 250 хүүхдээр хоолны талоньг илүү бичсэнээс 1,500.0 мянган төгрөгийн хүнсний материалыг илүү зарцуулсан,
- Сургалтын менежерт тэргүүлэх зэргийн нэмэгдлийг мэргэжлийн зэргийн хугацаа дуусан байхад олгосон 1,707.5 мянган төгрөгийн,
- Санхүүгийн тайланд тусгасан хүнсний материалын зарлагаас, нярвын тайланд хоолны талоноор зарцуулсан хүнсний материалын зарлага 15,650.2 мянган төгрөгөөр илүү тооцогдсон,
- Тендерт шалгарсан хүнсний материалыг нийлүүлэх компанитай гэрээ байгуулахдаа ирүүлсэн үнийн саналыг мөрдөөгүй, зах зээлийн үнийн 95 хувиар гэж гэрээ байгуулсан,

8426050290

- "Сургуулийн дотуур байрны хүүхдийн хоол, үдийн цайны хоол нийлүүлэх тендер"-ийн багц 2, багц 3-ыг гомдол гарсны дагуу Сангийн яамнаас хянан үзэж тус багцуудын тендерийг хүчингүй болгосон байхад гэрээ байгуулан худалдан авалтыг гүйцэтгэсэн,
- Гэрээний дагуу худалдан авалт хийгээгүй, хүнсний материал муудсан гэсэн гомдлын дагуу Шүүхийн шийдвэрээр 4,676.8 мянган төгрөгийг дотуур байрны хоолны зардлаас төлсөн,
- Өмнөх аудитаар өгсөн албан шаардлагыг хэрэгжүүлээгүй,
- Ажилчдын цалин хөлсийг тооцохдоо илүү цагийг буруу тооцон олгосон.

Асуудлыг онцолсон хэсэг

Ховд сумын ерөнхий боловсролын сургуулийн нь тайлант онд сумын ЗДТГ-т санал хүргүүлэн зарлуулсан "Сургуулийн дотуур байрны хүүхдийн хоол, үдийн цайны хоол нийлүүлэх тендер" зохион байгуулах ажил нь удаашралтай болон маргаантай байсны улмаас 2025 оны 5 дугаар сарын 28 хүртэл хүнсний материалыг шууд худалдан авалтаар гүйцэтгэсэн байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Тайлант онд сумын ОНХС-ын хөрөнгө оруулалтаар 37,0 сая төгрөгийн үндсэн хөрөнгө, боловсролын яамнаас 8.8 сая төгрөгийн ном үнэ төлбөргүй хүлээн авч, данс бүртгэлд тусгасан байна.

Бусад асуудлын хэсэг

Тайлант онд гүйцэтгэлийн төлөвлөгөөг 7 зорилтын хүрээнд 84 арга хэмжээ хэрэгжүүлэхээр тусгаж, гүйцэтгэлийг эрх бүхий албан тушаалтнаар дүгнүүлэн биелэлт 76 хувьтай үнэлэгдсэн байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР:

Х.БОЛДБААТАР



2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

(төгрөгөөр)			
Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>298,549,050.67</u>	<u>118,675,568.63</u>
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	158,945,799.68	29,816,560.34
312	Банканд байгаа бэлэн мөнгө	158,945,799.68	29,816,560.34
3121	Төгрөг	158,945,799.68	29,816,560.34
31211	Төрийн сангийн харилцах	158,945,799.68	29,816,560.34
33	АВЛАГА	52,324,878.50	-
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	50,351,078.50	-
335	Бусад авлага	1,973,800.00	-
3351	Байгууллагаас авах авлага	1,973,800.00	-
34	УРЬДЧИЛГАА	7,482,900.00	1,690,000.00
34600	Урьдчилж гарсан зардал	5,792,900.00	-
3471	Урьдчилгаа тооцоо	1,690,000.00	1,690,000.00
34712	Үндсэн хөрөнгө бэлтгэх урьдчилгаа	1,690,000.00	1,690,000.00
35	БАРАА МАТЕРИАЛ	79,795,472.49	87,169,008.29
351	Түүхий эд материал	6,551,238.49	15,357,474.29
35110	Тусгай зориулалттай материал	6,551,238.49	15,357,474.29
354	Хангамжийн материал	73,244,234.00	71,811,534.00
35420	Аж ахуйн материал	1,750,000.00	1,750,000.00
35440	Түлш, шатах тослох материал	9,600.00	9,600.00
35460	Хүнсний материал	1,432,700.00	-
35470	Бусад хангамжийн материал	70,051,934.00	70,051,934.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>3,923,762,337.78</u>	<u>3,882,143,310.66</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	3,923,762,337.78	3,882,143,310.66
391	Газар	9,240,000.00	9,240,000.00
392	Биет хөрөнгө	3,869,224,910.80	3,827,605,883.68
39201	Барилга, байгууламж, орон сууц	3,575,136,650.00	3,594,136,650.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(197,552,404.50)	(226,224,898.94)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	445,289,184.00	459,993,084.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(170,734,021.07)	(207,758,167.00)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	337,215,640.96	355,915,640.96
39208	Хуримтлагдсан элэгдэл	(162,474,582.51)	(190,800,869.26)
39217	Ном	42,344,443.92	42,344,443.92
393	Биет бус хөрөнгө	45,297,426.98	45,297,426.98
39301	Програм хангамж	1,075,000.00	1,075,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(765,573.02)	(765,573.02)
39303	Бусад биет бус хөрөнгө	44,988,000.00	44,988,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>4,222,311,388.45</u>	<u>4,000,818,879.29</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	<u>122,703,526.70</u>	<u>84,834,076.35</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	122,703,526.70	84,834,076.35
413	Өглөг	122,703,526.70	84,834,076.35
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	11,529,113.35	13,259,113.35
4136	Бусад өглөг	111,174,413.35	71,574,963.00
41361	Байгууллагад төлөх өглөг	111,174,413.35	71,146,963.00
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	-	428,000.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>4,099,607,861.75</u>	<u>3,915,984,802.94</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	4,099,607,861.75	3,915,984,802.94
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	837,165,419.00	837,165,419.00
51101	Өмч: - төрийн	837,165,419.00	837,165,419.00
512	Хуримтлагдсан үр дүн	2,397,450,379.03	2,213,827,320.22

Ховд сумын ерөнхий боловсролын сургуулийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

51210	Өмнөх үеийн үр дүн	2,397,450,379.03	2,397,450,379.03
51220	Тайлант үеийн үр дүн	-	(183,623,058.81)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	864,992,063.72	864,992,063.72
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>4,222,311,388.45</u>	<u>4,000,818,879.29</u>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл (төгрөгөөр)
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	3,111,147,320.59	3,131,899,235.80
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	286,673,620.59	50,924,235.80
120	Нийтлэг татварын бус орлого	286,673,620.59	50,924,235.80
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	283,128,764.69	50,924,235.80
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	2,738,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	17,778,400.00	2,380,000.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	265,350,364.69	45,806,235.80
120005	Түрээсийн орлого	2,544,855.90	-
120009	Бусад орлого	1,000,000.00	-
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,824,473,700.00	3,080,975,000.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	2,436,395,700.00	2,673,567,500.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	2,436,395,700.00	2,673,567,500.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	388,078,000.00	407,407,500.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	388,078,000.00	407,407,500.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	2,843,716,463.99	3,315,522,294.61
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,843,716,463.99	3,315,522,294.61
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,841,435,413.32	3,310,255,248.01
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,617,857,301.37	2,260,299,887.74
210101	Үндсэн цалин	1,617,857,301.37	1,378,952,293.26
210102	Нэмэгдэл	-	781,842,137.48
210104	Урамшуулал	-	99,505,457.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	418,005,186.47	267,666,000.00
210201	Тэтгэврийн даатгал	126,278,195.70	182,012,700.00
210202	Тэтгэмжийн даатгал	41,541,495.32	21,413,000.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	86,971,588.86	10,706,800.00
210204	Ажилгүйдлийн даатгал	21,961,537.00	10,706,800.00
210205	Эрүүл мэндийн даатгал	141,252,369.59	42,826,700.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	395,637,062.68	396,729,153.40
210301	Гэрэл, цахилгаан	13,965,949.33	15,791,040.40
210302	Түлш, халаалт	380,235,113.35	380,235,113.00
210303	Цэвэр, бохир ус	1,436,000.00	703,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	1,845,515.00	13,362,800.00
210401	Бичиг хэрэг	616,515.00	13,362,800.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,229,000.00	-
2105	Нормативт зардал	209,597,160.00	208,560,600.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	147,200.00	-
210502	Хоол, хүнс	209,449,960.00	208,560,600.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	4,368,591.00	4,597,000.00
210604	Урсгал засвар	4,368,591.00	4,597,000.00

Ховд сумын ерөнхий боловсролын сургуулийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	8,207,400.00	17,286,636.10
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,566,000.00	2,335,700.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	6,641,400.00	14,950,936.10
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	185,917,196.80	141,753,170.77
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	76,232,406.20	61,325,593.69
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	14,458,900.00	2,996,899.96
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	95,225,890.60	77,430,677.12
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2,281,050.67	5,267,046.60
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	2,281,050.67	5,267,046.60
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	2,281,050.67	5,267,046.60
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	<u>267,430,856.60</u>	<u>(183,623,058.81)</u>
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	<u>267,430,856.60</u>	<u>(183,623,058.81)</u>

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

(Төгрөгөөр)

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2023 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл	837,165,419	864,992,064	2,126,887,522	3,829,045,005
C07	Тайлант үеийн үр дүн	-	-	270,562,857	270,562,857
C08	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	837,165,419	864,992,064	2,397,450,379	4,099,607,861,075
D01	2025 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	837,165,419	864,992,064	2,397,450,379	4,099,607,861,075
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	(183,623,059)	(183,623,059)
D09	2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	837,165,419	864,992,064	2,213,827,320	3,915,984,802,094

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

(Төгрөгөөр)

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН	<u>2,843,252,100.00</u>	<u>3,086,093,000.00</u>
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	18,778,400.00	5,118,000.00
120	Нийтлэг татварын бус орлого	18,778,400.00	5,118,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	17,778,400.00	5,118,000.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	2,738,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	17,778,400.00	2,380,000.00
120009	Бусад орлого	1,000,000.00	-
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,824,473,700.00	3,080,975,000.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	2,436,395,700.00	2,673,567,500.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	2,436,395,700.00	2,673,567,500.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	388,078,000.00	407,407,500.00

Ховд сумын ерөнхий боловсролын сургуулийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	388,078,000.00	407,407,500.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	<u>2,795,143,934.19</u>	<u>3,215,222,239.34</u>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,795,143,934.19	3,215,222,239.34
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,746,054,523.52	3,146,818,392.74
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,848,297,666.34	2,209,948,809.24
210101	Үндсэн цалин	1,175,894,831.34	1,328,601,214.76
210102	Нэмэгдэл	593,698,572.38	781,842,137.48
210104	Урамшуулал	78,704,262.62	99,505,457.00
2102	Ажил олгогчоос төлөх НДШ	237,915,900.00	267,666,000.00
210201	Тэтгэврийн даатгал	161,782,800.00	182,012,700.00
210202	Тэтгэмжийн даатгал	19,033,300.00	21,413,000.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	9,385,600.00	10,706,800.00
210204	Ажилгүйдлийн даатгал	9,516,600.00	10,706,800.00
210205	Эрүүл мэндийн даатгал	38,197,600.00	42,826,700.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	383,546,949.33	397,390,453.40
210301	Гэрэл, цахилгаан	13,965,949.33	15,791,040.40
210302	Түлш, халаалт	368,706,000.00	380,777,613.00
210303	Цэвэр, бохир ус	875,000.00	821,800.00
2105	Нормативт зардал	123,789,000.00	146,019,428.00
210502	Хоол, хүнс	123,789,000.00	146,019,428.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,250,000.00	4,750,000.00
210604	Урсгал засвар	2,250,000.00	4,750,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	47,567,357.85	33,572,036.10
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	16,462,200.00	2,197,700.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	31,105,157.85	31,374,336.10
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	102,687,650.00	87,471,666.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	88,034,250.00	77,414,900.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	14,653,400.00	10,056,766.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	49,089,410.67	68,403,846.60
2132	Бусад урсгал шилжүүлэг	46,808,360.00	63,136,800.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	46,808,360.00	63,136,800.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	2,281,050.67	5,267,046.60
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	2,281,050.67	5,267,046.60
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>48,108,165.81</u>	<u>(129,129,239.34)</u>
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	48,108,165.81	(129,129,239.34)
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		158,945,799.68
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	158,945,799.68	29,816,560.34

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

(Төгрөгөөр)

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	3,421,163,500	3,209,955,192.7
21	УРСГАЛ ЗАРДАЛ	3,421,163,500	3,209,955,192.7
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	3,421,163,500	3,146,818,392.7

Ховд сумын ерөнхий боловсролын сургуулийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	2,261,454,700	2,209,948,809.2
210101	Үндсэн цалин	1,401,759,400	1,328,601,214.8
210102	Нэмэгдэл	782,224,300	781,842,137.5
210104	Урамшуулал	77,471,000	99,505,457.0
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	283,771,400	267,666,000.0
210201	Тэтгэврийн даатгал	192,964,600	182,012,700.0
210202	Тэтгэмжийн даатгал	22,701,700	21,413,000.0
210203	ҮОМШӨ-ний даатгал	11,350,800	10,706,800.0
210204	Ажилгүйдлийн даатгал	11,350,800	10,706,800.0
210205	Эрүүл мэндийн даатгал	45,403,500	42,826,700.0
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	573,938,100	397,390,453.4
210301	Гэрэл, цахилгаан	39,763,500	15,791,040.4
210302	Түлш, халаалт	532,590,600	380,777,613.0
210303	Цэвэр, бохир ус	1,584,000	821,800.0
2105	Нормативт зардал	164,027,200	146,019,428.0
210502	Хоол, хүнс	164,027,200	146,019,428.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	6,750,000	4,750,000.0
210604	Урсгал засвар	6,750,000	4,750,000.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	32,534,900	33,572,036.1
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	-	2,197,700.0
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	32,534,900	31,374,336.1
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	98,687,200	87,471,666.0
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	88,569,000	77,414,900.0
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	10,118,200	10,056,766.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	-	63,136,800.0
2132	Бусад урсгал шилжүүлэг	-	63,136,800.0
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	-	63,136,800.0
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	3,421,163,500	3,080,825,953.1
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	2,897,658,500	2,673,567,500.0
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	2,897,658,500	2,673,567,500.0
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	523,505,000	402,140,453.1
132001	Орон нутгийн төсвөөс	523,505,000	402,140,453.4
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	-	5,118,000.0
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих		2,738,000.0
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих		2,380,000.0
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	110,837,633.87	158,945,799.7
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	158,945,799.7	29,816,560.3

3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 109,526.5 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс 30,982.5 мянган төгрөгийн бүртгэл тайлагналын алдааг залруулж, баталгаажуулав. Үүнд:

- Санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайланд орлого, зардлын ангиллыг буруу тусгасан 30,982.5 мянган төгрөгийн зөрчил илэрсэн.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1-т "Хөрөнгө, төлбөр тооцооны тооллого хийх зохион байгуулалтын асуудлыг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, ерөнхий нягтлан бодогч нар хариуцна.", 12.2-т "Хөрөнгө, төлбөр тооцооны тооллогыг дараах тохиолдолд заавал хийнэ":, 12.2.1.жилийн санхүүгийн тайлан гаргахын өмнө; Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 72 дугаар зүйлийн 72.4-т "комиссын хурлаар тооллогын үр дүнг хэлэлцэж, тооллогын бүртгэлийг баталгаажуулж, холбогдох акт, материалын хамт ерөнхий нягтлан бодогчид тусгай жагсаалтаар шилжүүлэн өгөх" гэсэн заалтуудтай нийцэхгүй, санхүүгийн тайлагналын иж бүрэн, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Санхүүгийн тайлангийн аудиттай холбоотой зөрчил нь тогтоосон ерөнхий материаллаг байдлын түвшнээс бага бөгөөд өргөн тархаагүй тул **"Хязгаарлалттай"** дүгнэлт өгсөн.

Аудитаар илэрсэн залруулан бүртгээгүй 78,543.9 мянган төгрөгийн 8 зөрчилд¹ 3,297.5 мянган төгрөгийн 2 төлбөрийн акт тогтоож, 45,933.3 мянган төгрөгийн 3 албан шаардлага, алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 29,403.1 мянган төгрөгийн 2 зөвлөмж өгч, 1 асуудлыг хуульд хяналтын байгууллагад шилжүүлэхээр шийдвэрлэв.

3.1. ТӨЛБӨРИЙН АКТ

5.1.1. Дотуур байрны журналын ирцийн бүртгэлээс 250 хүүхдээр хоолны талонь илүү бичсэн 1,500.0 мянган төгрөгийн зөрчил илэрсэн нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3-т "Жинхэнэ хэрэгжилтийн", 13 дугаар зүйлийн 13.6-д "Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна", 18 дугаар зүйлийн 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ", 20 дугаар зүйлийн 20.1.4-д "Хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажаагүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх" гэсэн заалтуудтай нийцээгүй, санхүүгийн тайлагналын иж бүрэн, үнэн зөв байх, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоов.

3.1.2. Сургалтын менежер Я.Өмирханд тэргүүлэх зэргийн нэмэгдлийг мэргэжлийн зэргийн хугацаа дуусан байхад олгосон 1,707.5 мянган төгрөгийн зөрчил илэрсэн нь төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ", 20 дугаар зүйлийн 20.1.4-д "Хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажаагүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх", Боловсролын сайдын 2024 оны 9 дүгээр сарын 19-ний өдрийн А/95 дугаар тушаалын хоёрдугаар хавсралтаар баталсан "Ерөнхий боловсролын сургуулийн багш, удирдах ажилтанд мэргэшлийн зэрэг олгох, хүчингүй болгох журам"-ын 2.2-д "Мэргэшлийн зэргийн хүчинтэй хугацаа шатлал бүрд 5 жил байна", 2.5-д "Тэргүүлэх" мэргэшлийн зэргийг 3 удаа, "Зөвлөх" мэргэшлийн зэргийг 1 удаа бататгасан багш, удирдах ажилтны мэргэшлийн зэргийг сургалтын байгууллагад тухайн албан тушаалын үндсэн орон тоонд ажиллах хугацаанд байнгын хүчинтэйд тооцно", 4.7-д "Мэргэшлийн зэрэг бататгах, шатлал ахиулах хүсэлтийг мэргэшлийн зэргийн хүчинтэй хугацаанд гаргана", 5.1-д "Дараах тохиолдолд

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

багш, удирдах ажилтны мэргэшлийн зэргийг хэвээр хадгална”, Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2013 оны 08 сарын 15-ны өдрийн А/305 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан Багшлах эрх, мэргэжлийн зэрэг олгох, хасах журмын 1.1-д “Ерөнхий боловсролын сургуулийн багш (цаашид багш гэх)-д багшлах эрх, мэргэжлийн зэрэг олгох, хасах, ерөнхий боловсролын сургуулийн сургалтын менежер (цаашид ажилтан гэх)-т мэргэжлийн зэрэг олгох, хасах үйл ажиллагааг энэхүү журмаар зохицуулна” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн санхүүгийн тайлагналын нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоов.

3.2. АЛБАН ШААРДЛАГА

3.2.1. Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой асуудал.

Илрүүлэлт: Шилэн дансны тухай хуулийн дагуу мэдээллийг бүрэн үнэн зөв мэдээлээгүй зөрчил илэрсэн нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-д “мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх”, 4.1.2-д “мэдээлэл ойлгомжтой, ач холбогдолтой байх”, 4.1.3-д “тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх”, 6 дугаар зүйлийн 6.1-д “Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага, албан тушаалтан дараах мэдээллийг тогтмол мэдээлнэ”, 6.3-д “Энэ хуулийн 6.1.2-т заасан мэдээлэл дараах байдлаар илэрхийлэгдсэн байна”, 6.4-д “Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ”, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолын хавсралтаар баталсан журмын холбогдох заалтуудыг зөрчсөн, санхүүгийн тайлагналын нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага өглөө.

3.2.2. Хүнсний материалтай зарцуулалттай холбоотой асуудал.

Илрүүлэлт: Хүүхдийн хоолны зарцуулалтыг хянахад дараах зөрчил илэрлээ. Үүнд:

- Санхүүгийн тайланд тусгасан хүнсний материалын зарлагаас, нярвын тайланд хоолны талоноор зарцуулсан хүнсний материалын зарлага 15,650.3 мянган төгрөгөөр илүү тусгагдсан,

Хэрчсэн гурил, еэвэн, гурилан боорцог зэрэг 15,685.1 мянган төгрөгийн бэлэн гурилан хүнсийг худалдан авч хэрэглэж байгаа нь өмнөх аудитаар өгсөн албан шаардлагыг хэрэгжүүлээгүй зөрчил илэрсэн нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, Ерөнхий боловсролын сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1-д “сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээ” гэж ерөнхий боловсролын сургуульд суралцаж байгаа болон дотуур байранд амьдарч байгаа хүүхдийг эрүүл, шим тэжээллэг, аюулгүй хоол, хүнсээр сургуулиас ханган үйлчлэх үйл ажиллагааг” 5 дугаар зүйлийн 5.1.2-д “эрүүл, аюулгүй, шим тэжээллэг хоол, хүнсээр хүртээмжтэй хангах”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.6-д “Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна”, 18 дугаар зүйлийн 18.1-д “Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ”, 20 дугаар зүйлийн 20.1.4-д “Хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажаагүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх”, Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1-д “Энэ хуулийн 16 дугаар зүйлд заасан этгээд, хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй ...”, гэсэн заалтуудтай нийцээгүй, санхүүгийн тайлагналын үнэн зөв байх, тохиолдсон байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Нягтлан бодогч, нярав, тогооч нарт сахилгын хариуцлага тооцуулах албан шаардлага өгөв.

3.2.3. Худалдан авах ажиллагаатай холбоотой асуудал

Илрүүлэлт: Худалдан авах ажиллагаанд шалгарсан хүнсний материалыг нийлүүлэх компанитай гэрээ байгуулахдаа тендерт ирүүлсэн үнийн саналыг баримтлаагүй, зах зээлийн үнийн 95 хувиар гэж гэрээнд тусгаснаас 14,597.9 мянган төгрөгийг үнийн зөрүүд илүү төлсөн, өмнөх аудитаар өгсөн албан шаардлагыг хэрэгжүүлээгүй зөрчил илэрсэн нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д “Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ”, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1 “Захиалагч тендер шалгаруулалтын үр дүнг үнэн зөв, бүрэн нийтэлж, шалгарсан тендерийн үнийг мөрдөх үүрэгтэй”, 61 дүгээр зүйлийн 61.1-д “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль тогтоомжийг зөрчсөн ажилтан, албан тушаалтны үйлдэл нь гэмт хэргийн шинжгүй бол буруутай албан тушаалтанд” Төрийн албаны тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.1-д “Хөдөлмөрийн гэрээтэй ажилтанд Хөдөлмөрийн тухай хуулийн 123.2-т заасан сахилгын шийтгэлийг зөрчлийн шинж байдалд тохируулан ногдуулна”, Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1-д “Энэ хуулийн 16 дугаар зүйлд заасан этгээд, хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй ...” гэсэн заалтуудтай нийцээгүй, санхүүгийн тайлагналын нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: сахилгын хариуцлага тооцуулах албан шаардлага өглөө.

3.3. Хууль, хяналтын байгууллагад шилжүүлэх

5.3.1. Ховд сумын ЗДТГ-аас зарласан ХОАХОСЗДТГ/2025010203 дугаартай "Сургуулийн дотуур байрны хүүхдийн хоол, үдийн цайны хоол нийлүүлэх тендер"-ийн багц 2 Гурил, гурилан бүтээгдэхүүн, багц 3 Сүү, сүүн бүтээгдэхүүн худалдан авах тендерт шалгарсан Ортасу ХХК-ийн тендерийг гомдол гарсны дагуу Сангийн яамнаас хянан үзэж тус багцуудын тендерийг хүчингүй болгосон байхад гэрээ байгуулан худалдан авалтыг гүйцэтгэсэн. ХАА-д шалгарсан хүнсний материалыг нийлүүлэх компанитай гэрээ хийхдээ ирүүлсэн үнийн саналыг баримтлаагүй зөрчил нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д “Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ”, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1 “Захиалагч тендер шалгаруулалтын үр дүнг үнэн зөв, бүрэн нийтэлж, шалгарсан тендерийн үнийг мөрдөх үүрэгтэй” гэсэн заалтуудтай нийцээгүй, санхүүгийн тайлагналын нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Хууль, хяналтын байгууллагад шилжүүлэн шалгуулахаар МУ-ын Ерөнхий аудиторт уламжлахаар тогтов.

3.4 ЗӨВЛӨМЖ

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

3.4.1 Цалин хөлстэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Ажилчдын цалин хөлсийг тооцохдоо илүү цагийг буруу тооцон олгосон, 1-5 дугаар сарын цалингийн зөрүүг 5 дугаар сард гараар бодож нөхөж олгосон 24,726.3 мянган төгрөгийн зөрчил илэрсэн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3-т “Жинхэнэ хэрэгжилтийн”, 13 дугаар зүйлийн 13.6-д “Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна”, 18 дугаар зүйлийн 18.1-д “Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ” гэсэн заалтуудтай нийцээгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Илүү цагийн хөлсийг төрийн сангийн цалингийн нэгдсэн системээр тухай бүрд нь үнэн зөв тооцож олгож байх.

3.4.2 Нормативт зардалтай холбоотой асуудал

Илрүүлэлт: Асаутал нөхөрлөлөөс гэрээний дагуу худалдан авалт хийгээгүй, хүнсний материал муудсан гэсэн гомдлын дагуу шүүхийн шийдвэрээр 4,676.8 мянган төгрөгийг дотуур байрны хоолны зардлаас төлсөн зөрчил илэрсэн нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3-т “Жинхэнэ хэрэгжилтийн”, 13 дугаар зүйлийн 13.6-д “Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна”, 18 дугаар зүйлийн 18.1-д “Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ” гэсэн заалтуудтай нийцээгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Буруутай этгээдээр төлүүлж, байгууллагыг хохиролгүй болгох.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5-д “Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ” гэж заасны дагуу зөвлөмжийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг 2026 оны 03 дүгээр сарын 25-ны өдрийн дотор fas.audit.mn системд тайлагнан ажиллана уу.

Шийдвэрийн хэрэгжилтийг бүрэн хангуулж биелэлтийг Fas.audit.mn цахим системд нотлох баримтын хамт тайлагнан, Ховд аймаг дахь Төрийн аудитын байгууллагад 2026 оны 05 дүгээр сарын 20-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

4.1 Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Алдааны утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс:				Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
								тоо	Дүн	тоо	Дүн		
1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13	14
Ховд сумын ерөнхий боловсролын сургууль	Санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайланд орлого, зардлын ангиллыг буруу тусгасан	1	30,982.5			1	30,982.5	1	30,982.5				
Нийт дүн		1	30,982.5			1	30,982.5	1	30,982.5				

4.2 Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

(мянган төгрөгөөр)

Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Алдаа, зөрчлийн товч утга	Нийт алдаа, зөрчлийн дүн		Үүнээс:							
		Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн	
				Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12
Ховд сумын ерөнхий боловсролын сургууль	Дотуур байрны журналын ирцийн бүртгэлээс 250 хүүхдээр хоолны талоныг илүү бичсэн	1	1,500.00	1	1,500.00						
	Сургалтын менежер Я.Өмирханд тэргүүлэх зэргийн хугацаа дуусан байхад мэргэжлийн зэргийн нэмэгдэл олгосон	1	1,707.5	1	1,707.5						
	Хүнсний материалын зарцуулалтад дотоод хяналт хэрэгжүүлээгүй, өмнөх аудитаар өгсөн албан шаардлагыг хэрэгжүүлээгүй	1	31,335.4			1	31,335.4				
	ХАА-ны гэрээ байгуулахдаа ирүүлсэн үнийн саналыг мөрдөөгүй, өмнөх аудитаар өгсөн албан шаардлагыг хэрэгжүүлээгүй	1	14,597.9			1	14,597.9				
	ХАА-ны зохион байгуулалт хэрэгжилт нь хуульд нийцээгүй	1	0							1	0
	Ажилчдын цалин хөлсийг тооцохдоо илүү цагийг буруу тооцон олгосон.	1	24,726.3						1	24,726.3	
	Шүүхийн шийдвэр хоолны зардлаас төлсөн.	1	4,676.8						1	4,676.8	
Нийт дүн		7	78,543.9	2	3,207.9	2	45,933.3	2	29,403.1	1	0

4.3 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Алдаа, зөрчлийн товч утга	Нийт алдаа, зөрчлийн дүн		Үүнээс:					
	Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
			Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	2	3	4	5	6	7	8	9
Шилэн дансны тухай хуулийн дагуу мэдээллийг бүрэн үнэн зөв мэдээлээгүй	1	0			1	0		-
ДҮН	1	0			1	0		

5. ТӨСВИЙН ЗАХИРАГЧИЙН АНГИЛЛААР АУДИТАД ХАМРАГДСАН БАЙДАЛ БА САНАЛ ДҮГНЭЛТИЙН ТАЛААРХ МЭДЭЭЛЛИЙН НЭГТГЭЛ

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
А	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ	1	1				1		
	НИЙТ	1	1				1		